



MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 сарын 18-ны өдрийн 10:00 цагт ХУД, 3-р хороонд байрлах Төв дэлгүүрийн дэргэдэх Мираж ресторанд болов. Хурлыг Говь ХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа даргалж, ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Баяр, Б.Нандин-Эрдэнэ, 3.Шагдарсүрэн, ТУЗ-ийн ердийн гишүүн Ж.Оюунчимэг, Ц.Баатарсайхан, Дэд захирал Н.Сүрэнрагчаа нар панелистаар оролцов.

1. ХУРЛЫН ИРЦИЙГ ТАНИЛЦУУЛАХ

Тооллогын комиссын дарга М.Болортуяа танилцуулав.

Тооллогын комиссын дарга М.Болортуяа бүртгэлийн өдрөөр Говь ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо 780,112,500 байгаагаас 691,528,080 саналын эрхтэй, нийт 285 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирснээр хурлын ирц 88.64% болсон тухай хурлын даргад мэдэгдэж, хурлын ирц Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтад заасан шаардлагыг хангасан тул хурлын дарга хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулав.

2. ХУРЛЫН ДЭГИЙГ ТАНИЛЦУУЛАХ

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

1. Хурлын ирцийг гаргаж хурлын даргад мэдэгдэх
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах
3. Тооллогын комиссыг томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
4. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина:
 - 4.1. Компанийн 2018 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
 - 4.2. ТУЗ-өөс компанийн 2018 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
 - 4.3. 2017 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2018 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
 - 4.4. ТУЗ-ийн 2018 оны ажлын тайланг танилцуулах
5. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт
6. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон санал, шүүмжлэл
7. Саналын хуудсаар санал авах
8. Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэх

9. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах
10. Хурлаас гарах тогтоолын төсөлд Тооллогын комиссын санал хураалтын дүнг тусган танилцуулж, тогтоолыг батлуулах

Хурлын дарга Д.Гэрэлмаа хурлын дэгийг баталснаар хурлыг нээж, хурлын дэгийн дагуу илтгэлүүдийг эхлүүлэв.

3. ТООЛЛОГЫН КОМИССЫГ ТАНИЛЦУУЛАХ

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

Тооллогын комиссын даргаар Үйлдвэрлэл төлөвлөлтийн хэлтсийн дарга М.Болортуяа, нарийн бичгийн даргаар Ахлах аудитор Н.Сайнзул, гишүүдээр Ахлах нягтлан бодогч Ц.Цэцэгбадам, Хөдөлмөрийн харилцаа хариуцсан албаны дарга Б.Уянга гэсэн хариуцлагатай албан тушаалтнууд томилогдон ажиллаж байна.

4. ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫГ ТАНИЛЦУУЛАХ

4.1 Компанийн 2018 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах

Дэд захирал Н.Сүрэнрагчаа танилцуулав.

Сайн байцгаана уу, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Говь ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны гүйцэтгэл тайланг танилцуулъя. Та бүхэнд тараасан жилийн үйл ажиллагааны тайланд бүх мэдээллүүд багтсан байгаа. Үүнээс гол гол тоо баримтууд болон онцлох үйл явдлуудыг товч танилцуулъя. Танилцуулгатай холбоотой асууж тодруулах зүйл байвал хуваарийн дагуу асуулт хариултын цагт асууна уу.

2018 оны санхүүгийн гол тоон үзүүлэлтийг инфографик байдлаар харуулсан байгаа:

- Борлуулалтын орлого нийт 173.4 тэрбум төгрөг болж ба 2017 оноос 39%-ийн өсөлттэй, үүнд дотоод борлуулалт 111.8 тэрбум төгрөг буюу 50%-иар, гадаад борлуулалт 61.6 тэрбум төгрөг буюу 23%-иар өссөн үзүүлэлттэй байна. 2018 оны хувьд 29.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Нийт цэвэр ашиг 17.8 тэрбум төгрөг болж өмнөх оноос 1.5%-иар өссөн байна.
- Нийт төсөвт төлсөн татвар хураамж 28.1 тэрбум төгрөг буюу 2017 оноос 40%-ийн өсөлттэй байна.
- Компанийн нэгж хувьцааны үнэ одоогийн мөн үетэй харьцуулахад 44%-иар өссөнтэй холбоотой 2018 оны эцсийн байдлаар компанийн үнэлгээ 260.5 тэрбум төгрөг болж 2017 оноос 44%-иар өссөн байна.
- Нийт ажилтнуудын тоо 22% буюу 384 ажилтнаар нэмэгдсэн.

Хөрөнгө оруулалттай холбоотой мэдээлэл:

- 2018 онд 29.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. 2007 оноос хойш буюу хувьчлалаас хойш өссөн дүнгээрээ 86.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Өнгөрсөн онд хөрөнгө оруулалтын зардал өсөхөд барилга байгууламжийн төслийг хэрэгжүүлсэн нь нөлөөлсөн.
- Нийт хөрөнгө оруулалтын 15.0 тэрбум төгрөг буюу 51% нь үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 12.8 тэрбум төгрөг буюу 43% нь барилга байгууламжтай холбоотой хөрөнгө оруулалт эзэлж байгаа.
- Барилгатай холбоотой хийгдсэн 2 төсөл бол Галлериа Улаанбаатар дэлгүүрийг барьж 2018 оны 10-р сард ашиглалтад оруулснаар Дэлхийн хамгийн том ноолууран бүтээгдэхүүний дэлгүүртэй болсон. Мөн 7,000 м.кв хэмжээтэй үйлдвэрийн өргөтгөлийг барьж 2018 оны 11-р сард ашиглалтад оруулж сүлжмэлийн үйлдвэр болон оёмолын үйлдвэрүүд өргөтгөлийн барилга руу нүүж орсон.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлттэй холбоотой мэдээлэл:

- 2018 онд нийт ээрмэл утасны үйлдвэрлэл 367 тонн буюу 4%-ийн өсөлттэй, нэхмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл 478,000 ширхэг буюу 56%-ийн өсөлттэй, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл 800,000 ширхэг буюу 41%-ийн өсөлттэй, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл 82,000 ширхэг буюу 45%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Борлуулалттай холбоотой мэдээлэл:

- Нийт борлуулалтын хувьд 39%-ийн өсөлттэй байгаа.
- 2018.10.15-ны өдөр Галлериа Улаанбаатар төвийн 1 болон 2 дугаар давхарт шинэ салбар дэлгүүрээ нээсэн.
- Говь ХК-ийн нийт борлуулалтын 1/3 нь экспортын борлуулалт, үлдсэн 2/3 нь дотоод борлуулалт байдаг. Дотоодын борлуулалтаа задлаад үзэхэд нийт борлуулалтын 50% нь монгол хэрэглэгчид 50% нь гадаадын жуулчдын борлуулалт байдаг.
- Говь ХК-ийн салбар дэлгүүрээр үйлчлүүлсэн нийт жуулчдын задаргааг харахад 38.3% нь Солонгос улсын жуулчид, 28.1% нь Хятад улсын жуулчид буюу 66% нь Хятад болон Солонгос улсын жуулчид эзэлж байна.
- 2018 онд Монгол улсад 529,000 жуулчид ирсэн. Сүүлийн жилүүдэд Монгол улсад ирж байгаа жуулчдын тоо нэмэгдэж байгаа. 2018 онд Монголд ирсэн жуулчдаас 111,000 жуулчин буюу ойролцоогоор 21% нь Говь ХК-ийн нэрийн дэлгүүрээр үйлчлүүлсэн. 2019 оноос эхлээд Төв дэлгүүрээр үйлчлүүлж байгаа жуулчид гаднын картаар худалдан авалт хийх буюу шууд ам.доллараар тооцоо хийж болохоор болсон.
- Гадаад зах зээлийн хувьд Говь ХК-ийн нэрийн дэлгүүр 5, дэлхийн 13 орны 40 хотод 61 франчайзинг дэлгүүртэй үйл ажиллагаагаа явуулж байна.
- Говь ХК нь дотоод зах зээлд 71.3%, гадаад зах зээлд 63.1%-ийг эзэлж байна.
- Борлуулалтын нэр төрлийн бүтцийн хувьд 2017 онд сүлжмэл бүтээгдэхүүн 52%, оёмол бүтээгдэхүүн 23%, нэхмэл бүтээгдэхүүн 23%-ийг эзэлж байсан бол сүүлийн жилүүдэд оёмол бүтээгдэхүүнд илүү ач холбогдол өгч ажилласнаар 2018 онд сүлжмэл бүтээгдэхүүн 49%, оёмол бүтээгдэхүүн 30%, нэхмэл бүтээгдэхүүн 17%-ийг эзэлсэн байна. 2019 онд энэ харьцаа хадгалагдана.

- Бүтээгдэхүүн хөгжүүлэлттэй холбоотой хийгдэж буй ажлыг дурдвал нийт борлуулалтын 99.6%-ийг эзэлж буй ТОП 35 нэр төрлийн бүтээгдэхүүнийг үргэлжлүүлэн үйлдвэрлэж, борлуулалтад 0.4%-ийг эзэлж байсан 24 нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлээс хасаж, үйлдвэрийн ачааллыг багасган бүтээмжийг нэмэгдүүлэн ажилласан. Нийт борлуулалтын 82.5%-ийг ТОП 6 нэр төрөл эзэлж байгаа.
- Ноолуураар хийх боломжтой хамгийн нимгэн 100% ноолууран даавуугаар хослол үйлдвэрлэх туршилтыг эхлүүлэв. Цаашид нимгэн даавууны үйлдвэрлэл технологийг хөгжүүлж, чанар болон загварын өндөр төвшинд хослолыг массаар үйлдвэрлэнэ.

Онцлох үйл явдал:

- Таван жилд нэг удаа зохион байгуулагддаг Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал гардуулах GRAND BULL AWARDS ёслолоос Говь ХК "ШИЛДЭГ ХУВЬЦААТ КОМПАНИ"-аар шалгарав.
- "Монгол экспорт-2018" экспогоос Говь ХК-ийн хатгамалтай пальто, пиджак "ҮНДЭСНИЙ БАХАРХАЛТ БҮТЭЭГДЭХҮҮН"-ээр шалгарав.

2019 оны бизнес төлөвлөгөөний тухай:

- 2019 оны хувьд ТУЗ-өөр батлуулсан бизнес төлөвлөгөөгөөр борлуулалтын орлогыг 239.9 тэрбум төгрөг буюу 2018 оноос 38%-ийн өсөлттэй тэр дундаа гадаад борлуулалтыг 82.5 тэрбум төгрөг буюу 34%, дотоод борлуулалтыг 157.4 тэрбум төгрөг буюу 41%-иар өсгөхөөр тус тус төлөвлөсөн байгаа.
- Хөрөнгө оруулалтад 13.1 тэрбум төгрөг буюу 56%-иар бууруулах /шинэ тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт төлөвлөгдөөгүй бөгөөд өнгөрсөн онд хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөлтүүд графикын дагуу хийгдэнэ/, цэвэр ашгийг 27.5 тэрбум төгрөг буюу 55%-иар өсгөхөөр төлөвлөсөн.
- Нийт ажилтнуудын тоог 2,164 болгож 2.4%-иар өсгөх, нэхмэл бүтээгдэхүүнийг 522 мянган метр буюу 9%-иар өсгөх, сүлжмэл бүтээгдэхүүний тоо ширхгийг 938 мянган ширхэг болгож 17%-иар өсгөх, оёмол пальто, пиджакийг 90 мянган ширхэг болгож 9%-иар өсгөхөөр бизнес төлөвлөсөн.

Ингээд 2019 оны бизнес төлөвлөгөө болон 2018 оны бизнес төлөвлөгөөний биелэлтийг товч танилцууллаа. Та бүхэнд тарааж өгсөн 2018 оны жилийн тайлангаас бусад дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой. Мөн асуулт хариултын хэсэгт илүү дэлгэрэнгүй мэдээлэл авч болно. Баярлалаа.

4.2 ТУЗ-өөс компанийн 2018 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

ТУЗ-ийн зүгээс Гүйцэтгэх удирдлагын багийн танилцуулсан тайланд хийсэн дүгнэлтийг та бүхэнд танилцуулъя.

Говь ХК-ийн ТУЗ нь тус компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлаад компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэхдээ Компанийн тухай хууль, холбогдох хууль

дүрэм журам, хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан Говь ХК-ийн дүрмийг чандлан мөрдөж ажиллаж ирлээ. Гүйцэтгэх удирдлагын багийн хувьд ТУЗ-ийн зүгээс гаргасан шийдвэр зөвлөмж, төлөвлөгөө зорилтуудыг амжилттай дагаж биелүүлэх чиглэлээр хамтарч ажилласан болно. 2018 оны ерөнхий гүйцэтгэлийг Дэд захирал Н.Сүрэнрагчаа та бүхэнд танилцууллаа.

2018 онд их онцлог, ихээхэн хөгжүүлэлт, өргөжүүлэлт хийсэн жил болсон гэдгийг та бүхэн анзаарсан байх. Бид бүхний хувьд Мөлхөө ээрэх үйлдвэрийг ашиглалтад оруулж утасныхаа чанарыг сайжруулах, нэхмэлийн гүйцэтгэн боловсруулах технологийг Япон улсаас суралцаж эзэмших, дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц пиджак үйлдвэрлэх технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, гадаад дотоод захиалгыг үйлдвэрлэлтэй нягт хослуулан үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, гадаад дахь нэрийн болон гэрээт дэлгүүрүүдийн үйл ажиллагааг сайжруулах замаар борлуулалтыг нэмэгдүүлэх, санхүүгийн үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллахад чиглэсэн.

Жилээс жилд шинэ технологиудыг нэвтрүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэн борлуулалтын сувгуудаа тэлэх ажлын үр дүнгүүд эхний байдлаар нэлээд эерэг байдлаар дүгнэгдсэн гэдгийг та бүхэн сая Н.Сүрэнрагчаа захирлын илтгэлээс сонссон гэж бодож байна.

Иймд ТУЗ-ийн зүгээс Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2018 онд төлөвлөсөн зорилгоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж дүгнэснийг та бүхэнд танилцуулж байна. Энэ боломжийг ашиглаад гүйцэтгэх удирдлагын багийнхандаа талархал илэрхийлье.

4.3 2017 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2018 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.

Та бүхэнд ногдол ашгийн мэдээллийг танилцуулахаас өмнө өнгөрсөн онд Говь ХК-ийн хувьцааны арилжаа хөрөнгийн зах зээл дээр ямар байсан талаарх мэдээллийг товч танилцуулъя.

2018 онд болсон онцлох зүйл бол манай компани хувьцаагаа 100 хуваахаар шийдвэрлэсэн. 2018.10.03 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг /ирц 88.72%/ зарлан хуралдуулсан. Энэхүү хурал дээрээ компанийн нэгж хувьцааг 100 хуваах тухай асуудлыг хэлэлцэн 99.99% саналаар баталсан. Хувьцаа хуваахаар шийдвэрлэсэн гол зорилго нь:

- Хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, арилжааг идэвхжүүлэх
- Зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигч нарын тоог нэмэгдүүлэх байсан.

Бид бүхний гаргасан шийдвэрийг үндэслээд Санхүүгийн зохицуулах хорооны 2018.11.30-ны едрийн хурлаар зөвшөөрсөн шийдвэрийг гаргасан.

- Хувьцаа хуваахаас өмнө нийт 7,801,125 ширхэг хувьцаа гаргасан байсан бол хувьцаа хуваасны дараа 780,112,500 болж 100 дахин өссөн.
- Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 100 төгрөг байсан бол хуваасны дараа 1 төгрөг болж 100 дахин буурсан.
- Хувьцаат капиталын дүнд өөрчлөлт ороогүй.

- 2018.11.30-ны өдрийн байдлаарх хаалтын ханш 33,000 төгрөг байсан бол хувьцаа хуваасны дараа 330 төгрөг болж 100 дахин буурсан.
- Компанийн зах зээлийн үнэлгээнд өөрчлөлт ороогүй. Тухайн үед 257.4 тэрбум төгрөгийн үнэлгээтэй байсан.

2018 оны хувьцааны арилжааны графикыг танилцуулъя. Үнийн хувьд хувьцаа хуваах тухай асуудал гарахаас өмнө буюу ээлжит бус хурал зарлахаас өмнө хувьцааны ханш дунджаар 24,000 төгрөг буюу 100 хуваасны дараах ханш руу шилжүүлбэл 240 төгрөг байсан. 8 сарын сүүлээр ээлжит бус хурал зарлан хувьцаа хуваах гэж буй тухай мэдээллийг олон нийтэд зарласнаас хойш хувьцааны ханш нэлээд өссөн.

Хувьцаа хуваасантай холбоотой арилжааг 2018.12.01-ний өдрөөс 2018.12.13-ны өдрийн хооронд түр зогсоож үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсны дараа 2018.12.14-ний өдрөөс эхлэн сэргээсэн. Арилжааг сэргээснээс хойш арилжааны идэвх нэлээд нэмэгдсэн байгааг энэхүү графикнаас харж байгаа байх.

Хувьцааны үнэ 2018 оны хаалтын ханшаар 339.89 төгрөг байсан. Энэ нь 2017 онтой харьцуулахад 43.5%-иар өссөн, дундаж үнэ 266.8 төгрөг байсан буюу 2017 оноос 61.4%-иар өссөн үзүүлэлттэй байсан.

Арилжаалагдсан тоо ширхгийн хувьд дунджаар өдөрт 7,862 ширхэг хувьцаа арилжаалагдсан нь 2017 оноос 13 дахин өссөн үзүүлэлттэй байна. Арилжааны үнийн хувьд өдөрт дунджаар 17.9 сая төгрөгийн хувьцаа арилжаалагдаж байсан нь өмнөх оноос 67.4% өссөн үзүүлэлттэй байсан байна. Нийт 4.3 тэрбум төгрөгийн хувьцаа арилжаалагдсан байна. Зах зээлийн үнэлгээ 2018 оны сүүлээр 260.5 тэрбум төгрөг болж 2017 оноос 43.5%-иар өссөн байна.

Энэхүү гол үзүүлэлтүүдийг Хөрөнгийн бирж дээр хувьцаа нь арилжаалагдаж байгаа бусад нээлттэй хувьцаат компаниудтай харьцуулж үзвэл өнгөрсөн оны хувьцааны арилжааны тоо ширхгээрээ 19-р байр, арилжааны үнийн дүнгээрээ 6-р байр, зах зээлийн үнэлгээгээрээ 4-р байранд жагссан үзүүлэлттэй байна.

Хувьцаа хуваасны дараах үзүүлэлтийг танилцуулбал, 2018.01.01-2018.11.30 буюу хувьцаа хуваагдахаас өмнө хувьцааны дундаж үнэ 263 төгрөг байсан бол 2018.12.14-2019.03.30 буюу хувьцаа хуваагдсаны дараа 331 төгрөг болж 26%-иар өссөн. Өдрийн арилжааны дундаж үнэ хувьцаа хуваагдахаас өмнө 16,192,387 төгрөг байсан бол хувьцаа хуваагдсаны дараа 22,335,309 төгрөг болж 38%-иар өссөн. Өдөрт арилжаалагдсан дундаж тоо 586 ширхэг байсан бол хувьцаа хуваагдсаны дараа 65,679 ширхэг болж 112 дахин өссөн. Хувьцаа эзэмшигчдийн тоо 16,391 хүн байсан бол хувьцаа хуваагдсаны дараа 16,964 хүн болж 573 хүнээр нэмэгдсэн байна. Ингэснээр арилжаалагдсан тоо ширхгээрээ 19-т орж байсан бол 4-р байр, арилжааны дундаж дүнгээрээ 6-д орж байсан бол 4-р байр, хувьцаа эзэмшигчдийн тоогоороо 3-р байрт орж байна.

2017 оны ногдол ашгийн тараалтын тайланг танилцуулъя. 2017 онд цэвэр ашгаас нэгж хувьцаанд 220 төгрөгийн ногдол ашиг зарласан. Нийт дүнгээр 1.7 тэрбум төгрөгийг ногдол ашигт тараасан. 2018 ондоо багтаад ногдол ашгаа 100% тараасан ба компани дээр ногдол ашгийн 90%-ийг буюу 1,540,073,920 төгрөгийг тарааж үлдсэн 10%-ийг буюу 176,173,580 төгрөгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр зуучлуулан тараасан.

2018 оны цэвэр ашгаас зарласан ногдол ашгийн мэдээллийг танилцуулъя. ТУЗ-ийн зүгээс нэгж хувьцаанд 6.8 төгрөг олгохоор шийдвэрлэсэн. Энэ нь өмнөх оноос 3 дахин өссөн үзүүлэлттэй байгаа. Нийт 5.3 тэрбум төгрөг буюу цэвэр ашгийнхаа 30%-ийг ногдол ашигт тараахаар шийдвэрлэсэн. 2019.03.28-ны байдлаар Говь ХК-ийн хувьцааг эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчид ногдол ашиг авах эрхтэй.

Та бүхэн ногдол ашгаа 2019.04.25-ний өдрөөс эхлэн дараах 3 аргаар авах боломжтой.

1. Компани дээр ирж касснаас бэлэн мөнгөөр авах
2. www.gobi.mn вэб сайт дээр байршуулсан анкетыг бөглөн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга руу имэйлээр илгээснээр, банкны харилцах дансандаа шилжүүлүүлэн авах
3. 2019 оны эцэст ҮЦТХТ-өөр зуучлуулан үнэт цаасны дансандаа шилжүүлүүлэн авах

4.4 ТУЗ-ийн 2018 оны ажлын тайланг танилцуулах

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

Говь ХК засаглалын хувьд ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой тайлангаа анх удаа дэлгэрэнгүй байдлаар хувьцаа эзэмшигч та бүхэндээ танилцуулж байгаадаа баяртай байна. Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 9 гишүүнтэй. Хараат бус /салбар бүрийн чиглэлээр мэргэшсэн/ 5 гишүүн, ердийн 4 гишүүнтэй. Засаглалын хувьд сайн засаглалын элемент бүрдсэн бүтэцтэй байгаа.

ТУЗ-ийн үндсэн үүрэг нь үр ашгийн мониторингийг хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулалтыг ханган хувьцаа эзэмшигч та бүхнийхээ эрхийг хангахын төлөө оршиж байдаг нэгж юм. Өмнө нь удирдаж байсан ТУЗ-ийн дарга Д.Хүрэлбаатар захирлын оруулсан хувь нэмэр асар их гэдгийг хэлмээр байна.

1. ТУЗ-ИЙН АЖЛЫН ТАЙЛАН

ТУЗ нь 2018 онд нийт 9 удаа хуралдсан /Ээлжит хурал-6, Ээлжит бус хурал-3/

Хурлын үр дүн: 35 асуудлыг хэлэлцэн 33 шийдвэр, 33 тогтоол гаргав. Мөн чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 35 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, хяналт тавьж ажилласан.

Онцлох ажил:

- Компанийн санхүү, үр дүн, үйл ажиллагааны тайлантай тогтмол танилцаж, удирдлагын багийг стратегийн төвшинд чиглүүлэн удирдлагаар хангаж ажиллахаас гадна, хувьцаа эзэмшигч нарын эрхийг хамгаалан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан.
- Компанийн сайн засаглалыг бэхжүүлэх зорилгоор засаглалын бодлогын бичиг баримтыг шат дараатайгаар шинэчлэн баталж, "Говь ХК-ийн Засаглалын дүрэм журмууд" гэсэн эмхэтгэлийг гаргав. Энэ ажилд ТУЗ-ийн гишүүд маань маш их үүрэг оролцоотой байсныг онцлон хэлж, талархлаа илэрхийлмээр байна.
- ТУЗ-ийн дэргэдэх хороод хурлаараа хэлэлцсэн асуудал, үр дүнг ТУЗ-ийн хурал дээр тогтмол тайлагнан нэгдсэн шийдвэрийг гарган ажилласан.

2. ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРООНЫ ТАЙЛАН

Бүрэлдэхүүн:

Эрсдэл, аудитын хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Нандин-Эрдэнэ
Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн З.Шагдарсүрэн
ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хулан

Хуралдсан тоо: 6 удаа /Ээлжит хурал-4, Ээлжит бус хурал-2/

Хурлын үр дүн: 26 асуудлыг хэлэлцэн 27 шийдвэр, 5 тогтоол гаргав. Мөн хорооны чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 43 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, хяналт тавьж ажилласан.

Онцлох ажил:

- Эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд Эрсдэлийн бодлогын бичиг баримтыг боловсруулах, эрсдэлийн мониторинг, ангилалыг сайжруулах ажлуудыг Эрсдэлийн удирдлагын багаар гүйцэтгүүлэн, хяналт тавьж, чиглүүлэн ажилласан.
- Хяналтын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын горимуудыг нэвтрүүлэх, Говь ХК-ийн дотоод аудитын дүрмийг олон улсын стандартад нийцүүлэн өөрчлөх зэрэг ажлуудыг Дотоод аудитын хэлтсээр гүйцэтгүүлэн, хяналт тавьж, чиглүүлэн ажилласан.

3. НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ТАЙЛАН

Бүрэлдэхүүн:

Нэр дэвшүүлэх хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Баяр
Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа
ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Баатарсайхан

Хуралдсан тоо: 2 удаа

Хурлын үр дүн: 9 асуудлыг хэлэлцэн 11 шийдвэр, 2 тогтоол гаргав. Мөн хорооны чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 9 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, хяналт тавьж ажилласан.

Онцлох ажил:

- Энэ хороог засаглалын хороо гэж хэлж болно. ТУЗ-ийн өөрийн үнэлгээг жил бүр хийдэг бөгөөд энэ жил мөн хийж, үр дүнд нь үндэслэн ТУЗ болон хороодын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд цаашид гүйцэтгэх ажлуудыг хэлэлцсэн бөгөөд Компанийн засаглалын өөрийн үнэлгээг 2 дахь жилдээ хийж МХБ болон компанийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд тайлагнан ажилласан.
- Компанийн тогтвортой үйл ажиллагааг өндөр чадвартай удирдлага, зохион байгуулалтаар тасралтгүй хангах хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор "Эрх бүхий албан тушаалтнуудын талаар баримтлах бодлого"-ыг боловсруулж батлав.
- Компанийн удирдлагын багийнхныг сурган хөгжүүлэх зорилгоор 2 удаа нийт удирдлагын багийг хамарсан сургалтыг зохион байгуулсан.

4. ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ ТАЙЛАН

Бүрэлдэхүүн:

Цалин урамшууллын хорооны дарга:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа

Гишүүд:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Такэши Камбэ

ТУЗ-ийн ердийн гишүүн Ж.Оюунчимэг

Хуралдсан тоо: 2 удаа

Хурлын үр дүн: 7 асуудлыг хэлэлцэн 7 шийдвэр гаргав. Мөн хорооны чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 15 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, хяналт тавьж ажилласан.

Онцлох ажил:

- Компанийн хэмжээнд цалин урамшуулал, нийгмийн халамжийн хүрээнд хийгдсэн ажлын тайлантай хагас жил тутам танилцан, ажлын үр дүнтэй холбогдсон урамшууллын системийг шинэчлэх, компанийн цалингийн доод хэмжээг тогтоох, Эрх бүхий албан тушаалтнуудын урамшууллын дээд хязгаарыг тогтоох зэрэг голлох ажлууд дээр шийдвэр, зөвлөмжийг өгч ажилласан.
- Хорооны чиг үүргийнхээ дагуу өнгөрсөн оны цалин урамшууллын гүйцэтгэлд хяналт тавьж, ирэх жилийн цалин урамшууллын төсвийг баталснаас гадна тус хорооны чиглүүлгийн дагуу компанийн ажилтнуудыг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн эхлээд байна.

Холбогдох дүрэм журмын дагуу хамтарч ажилладаг ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагын багтаа баярлалаа. Мөн компанийн засаглалын суурийг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан өмнөх ТУЗ-ийн дарга Д.Хүрэлбаатар захиралдаа маш их баярлалаа. Анхаарал хандуулсан та бүхэндээ баярлалаа. Хэлэлцэх асуудалтай холбоотой гол илтгэлүүдийг тавьж дууслаа.

Хурлын дэгийн дагуу хэлэлцэж байгаа асуудлуудтай холбоотой асуулт, хариултын цаг эхэлж байна.

5. АСУУЛТ ХАРИУЛТ

/Хүн тус бүр 3 минут/

АСУУЛТ 1

Хувьцаа эзэмшигч Н.Хүрэлбаатар: Манай борлуулалтын орлого 2018 онд 39%-иар өссөн байхад цэвэр ашиг 1.5%-иар өссөн байна. Энэ өсөлт яагаад 39%-иа дагаж өссөнгүй вэ? Юу юун дээр зардал гарсан талаар хариулт өгнө үү. Би зардлын задаргааг харлаа, галын осолтой холбоотой алдагдал 5 тэрбум төгрөг байсан бол бусад зардлын задаргааг танилцуулна уу? Дараа жил борлуулалтаа дахиад 39%-иар өсгөнө гэж төлөвлөсөн байна. Энэ жилийн алдагдал гарзыг тооцвол цэвэр ашиг 80%-иар өсөх боломжтой харагдаж байхад яагаад түүнээс багаар өснө гэж төлөвлөсөн бэ?

Хариулт:

Дэд захирал Н.Сүрэнрагчаа: Өнгөрсөн жилийн цэвэр ашгийн өсөлт маань борлуулалтын 39%-ийн өсөлтдөө хүрээгүй, 1.5%-иар өссөн байгаа. Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйл бол

валютын ханшийн алдагдалд 6.5 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн. Хэрэв энэ алдагдлыг хүлээгээгүй байсан бол цэвэр ашиг маань борлуулалтын орлогын өсөлтийн дагуу 39%-иар өсөх боломж байсан.

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Мөн нэмээд хэлэхэд 2017 онд 1 кг ноолуур 70,000 төгрөгийн үнэтэй байсан бол 2018 онд 43%-иар өсөж 102,000 төгрөгийн үнээр түүхий эд худалдаж авсан. Харин 2019 онд түүхий эд 1 кг ноолуур 130,000 гаруй төгрөг болж өссөн. Тэгэхээр 2017 онтой харьцуулахад 2018, 2019 онд түүхий эдийн үнэ 72% орчим өсөлттэй байгаа.

АСУУЛТ 2

Хувьцаа эзэмшигч н.Хүрэлбаатар: Тайланд борлуулсан бүтээгдэхүүний өртөг нь борлуулалтын өртөгтэй адилхан байна. Ханшийн алдагдал 6.5 тэрбум нь байна. Борлуулалт маркетингийн зардал, хүүний зардал чинь өсөөд байгаа юм биш үү, үүн дээр тайлбар өгнө үү?

Хариулт:

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Монгол улс зах зээлийн нийгэмд ороход 1,000 тн түүхий ноолуур авдаг улс байсан бол өнгөрсөн жил 10,000 тн орчим түүхий ноолуур авсан. Төрийн бодлогын хувьд Монгол улс 10,000 тн ноолуур үйлдвэрлэж байгаа ч 1 их наяд төгрөгийн ч орлого олохгүй байгаа. Тийм учраас нийт Монгол улсад үйлдвэрлэж байгаа түүхий ноолуурынхаа 50%-ийг нь Монголдоо эцсийн бүтээгдэхүүн бий болгоё, ажлын байр бий болгоё, Хөгжлийн банкнаас Монголын ноолуурын үйлдвэрүүдийг тоног төхөөрөмж худалдаж авахад, хөрөнгө оруулалт хийхэд, түүхий эд худалдаж авахад нь дэмжлэг үзүүлбэ, та нар үйлдвэрлэлийн хэмжээг өсгөөч гэсэн төрийн бодлоготой байсан.

Бид төрийн бодлогын дагуу өнгөрсөн хоёр жилийн хугацаанд үйлдвэрлэлийнхээ хэмжээг өсгөх бодлого зорьж 2018 онд гэхэд ажилчдынхаа тоог 384-өөр өсгөсөн. Үйлдвэрлэлийн хэмжээг өсгөөд явах тусам гарсан асуудал нь дэлхийн зах зээл дээр бүтээгдэхүүнээ борлуулахын тулд бид Хятад улстай өрсөлддөг. Жишээ нь бид 1 кг ноолуурыг дунджаар 130,000 төгрөгөөр худалдаж авдаг бол бүтээгдэхүүний хэмжээг өсгөөд, үйлдвэрлэлийн хэмжээг өсгөөд, борлуулалтаа өсгөө гэхээр дэлхийн том худалдан авагчид Говь компани дээр ирээд 1 гр ноолуурыг 14-15 центээр худалдаж авах шаардлага тавьдаг. Бүх зүйлийг Хятад улстай харьцуулдаг.

Өнгөрсөн хугацаанд бидэнд ямар бэрхшээл байв гэхээр гал түймрийн осол гарсан нь бид бүхний хариуцлагагүйгээс болсон нь үнэн. Бидний гэрээ хийж ажил гүйцэтгүүлж байсан компани орой ажил тараад явахдаа болгоомжгүй байдал гаргаснаас шалтгаалсан. Гал гарсан өдрийн орой 20:20 цагийн үед үйлдвэрийн дээврээс утаа гарч байгаа ажиглагдсан. Шалгаад үзэхэд гал ажиглагдаагүй. Цагийн дараа гал командынхныг авч ирээд шалгаад үзэхэд гал доогуураа дүйж яваад шаталт унтраахад төвөгтэй болсон.

Мэдээ сонсож байхад Парисын Дарь эхийн сүм шатсан нь мөн адил барилгын засвар хийгдэж байгаад 06:20 цагт гал мэдрэгч нь ажиллаад, дахиад 23 минутын дараа нэлээн том хэлбэрээр илэрсэн. Галын гамшиг бол аймшигтай.

Говь ХК хоёр даатгалын компанитай даатгалын сайн гэрээ хийсэн байсны хүчинд Говь ХК хохирол хүлээхгүйгээр даатгалын компаниас бүрэн нөхөн төлбөрөө авч засвар хийж чадсан байгаа.

Төрийн бодлого, Хөгжлийн банкны зээлийн бодлоготой уялдуулаад Говь ХК 2019 онд 2,114 ажилтантай байгаа. Энэ жил нэг ч ажилтан нэмж авахгүй. Одоо байгаа хүн хүчээрээ бүтээмжээ нэмэгдүүлж борлуулалтаа өсгөхөөр ажиллана.

Та бүхэн мэдэж байгаа байх, Говь ХК-ийн борлуулалтад Монгол улсад ирж байгаа жуулчид асар хувь нэмэртэй байдаг. Монгол улсад ирж байгаа жуулчдын тоогоор 2-т ордог Солонгос улсын хоёр дахь авиа компани Asiana Airlines 2019.07.09-ний өдрөөс эхлээд 290 хүний суудалтай онгоцоор 8 сарыг дуустал 7 хоногт 7 нислэг хийнэ. 2018 онд 85,000 Солонгос жуулчин ирж байсан бол 2019 онд 160,000 жуулчин ирнэ гэж төлөвлөж байгаа. Мөн 2019.03.29-нд Монгол улсад БНСУ-ын Ерөнхий сайд айлчлалаар ирэхэд Засгийн газар Говь ХК-ийн үйлдвэрлэсэн ноолууран пальтог манайхаас худалдан авч бэлэглэсэн байгаа. Анх өгсөн размерын хэмжээ буруу байсантай холбоотой Монголд ирсэн орой нь 22:00 цагаас хэмжээ аваад маргаа өглөө 09:00 цагт пальтог хүлээлгэж өгөх хэмжээний төвшинд бид үйлдвэрлэж чаддаг болсон гэдгээ манай хамт олон харуулж чадсан. БНСУ-ын Ерөнхий сайдын Монголд ирсэн сайхан сэтгэгдлүүдийн нэг нь МУ-ын засгийн газраас бэлэглэсэн Говь ХК-ийн ноолууран пальто байлаа гэж өгүүлсэн байгаа.

АСУУЛТ 3

Хувьцаа эзэмшигч н.Хүрэлбаатар: Борлуулалт маркетингийн зардал болон хүүгийн зардал хоёр дахин өссөн байгааг тайлбарлана уу?

Хариулт:

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Би өөрөө 2008.08.06-нд Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал болсон. Намайг захирал болж байх үед 1 кг ноолуурыг 25,000 төгрөгөөр худалдаж авдаг байсан. Жилийн туршид 100 пальто үйлдвэрлээд 30 пальто борлуулдаг байсан. Энэ үеийг бодоход бид аажим аажмаар үйлдвэрлэж чаддаг болж байгаа. Дэлхийн зах зээл дээр бид чаддаг болсноо нотлон харуулах, мөн Монголынхоо худалдан авагчдад бүтээгдэхүүний сурталчилгааг хийхэд маркетингийн зардал зайлшгүй гаргах хэрэгтэй.

Нөгөө талдаа бөөний худалдан авагчид бүх зүйлийг Хятадтай харьцуулдаг. Хятадад утсаа хийгээд Ази номхон далайн халуун оронд сүлжмэлийн үйлдвэрээ байгуулаад асар бага зардлаар бүтээгдэхүүнээ үйлдвэрлээд АНУ руу татваргүй гаргадаг. Дэлхийн өрсөлдөөн бол бидний Монголдоо өрсөлдөж байгааг бодоход хэд дахин ширүүн байгаа.

Мөн 2019.02.01-ний өдрөөс Говь ХК нимгэн ноолууран даавууг үйлдвэрлэж эхлээд ноолууран хослол хийдэг болсон. Нимгэн даавуу гэдэг бол сүлжмэлийн цамцыг зарахад гр-аар ярьдаг. Бид нар сүлжмэл цамцыг үнэтэйдээ 1 гр нь 25 центээр зардаг бол нимгэн ноолууран даавуугаар хийсэн энэ бүтээгдэхүүнийг 1 гр нь 30 центээр зарах хэмжээний үнэ цэнэтэй бүтээгдэхүүнийг хийж чаддаг болсон.

Өнгөрсөн жил 384 ажилтан шинээр авч чадсан ч гэсэн шинэ ажилчдыг сургах ажил бол тийм амар биш юм. Монгол хүмүүс Солонгосын зах зээл рүү өндөр цалинтай ажил хийхээр явдаг. Өмнөх жилүүдэд манайд уул уурхай хөгжиж байх үед манай инженерүүд уул уурхайн компани руу ажиллахаар ажлаасаа их гардаг байсан. Энэ хүмүүсийг бид буруутгахгүй. Учир нь уул уурхайн компаниуд биднээс 2-3 дахин өндөр цалин өгч чаддаг.

Бид 2018 оны үйл ажиллагааны нийт цэвэр ашгаасаа 30%-ийг ногдол ашигт тарааж байгаа. Дэлхийн дундаж ногдол ашиг бол 30% байдаг. Өнөөдөр бид 2019 онд ханшийн алдагдал үүсгээд байгаа зээлийн хэмжээг бууруулах бодлого барьж байна.

2018 онд Хөгжлийн банкнаас ноолуурын үйлдвэрүүдэд эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээл олгодог байсан бол 2019 онд нэг ч төгрөгийн зээл олгохгүй байгаа. Би өөрийнхөө Говь ХК-д эзэмшдэг хувийн хувьцаагаа барьцаалаад Монголын арилжааны банкнаас зээл аваад 2019 оны түүхий эдээ худалдаж авахаар ажиллаж байгаа.

Жилд ганц удаа уулздаг Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр олон зовлон яримааргүй байгаа ч байдал бол тийм амар биш байгаа. Ер нь 2 жилийн хугацаанд түүхий эдийн үнэ нь 74% өсч байхад тэсээд гарах салбар Монголд байхгүй байх гэж бодож байна. Монгол улс 800,000 өрхтэй. 210,000 малчин өрхтэй. Малчин өрхийн амьдрал бол ноолуурын үнээс, махны үнээс хамаарна. Монгол улсын эрх ашгийн хувьд бол энэ маш зөв зүйтэй зүйл. Харин үйлдвэр эрхэлж байгаа бидний хувьд бол тийм амар зүйл биш. Гэхдээ биднийг энэ бизнесийг хий гэж хэн ч шахаж ажиллуулаагүй. Бид нар сайн дурын үндсэн дээр энэ компанийн хувьцааг нь эзэмшээд ашигтай, орлоготой улам сайн болгоно, Монгол хүн юм хийж бүтээж чадах ёстой гэсэн эрмэлзлэлийн доор энэ бүхнийг хийж байгаа. 2018 онд ханшийн өсөлт ямар байсныг та бүхэн бас мэдэж байгаа байх.

Ирэх жил бол сонгуулийн жил. Бид энэ жил нөөцөө асар бууруулах гэж байгаа. Өнгөрсөн оны 6 сараас хойш Тоёота компанийн Вьетнамын үйлдвэрийн дарга байсан мундаг хүнийг авчирч үйлдвэрийнхээ бүтээмжийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нөөцийг бууруулах тал дээр асар их зүйл хийж байгаа. 2019 он дуусаад 2020 он гэхэд Говь ХК дахиад шинэ шатанд гарах төлөвлөгөөтэй байна.

Бид ирээдүйд жилд 900-1,000 тн ноолуур худалдаж аваад бүтэн жил дуусаад дараа жилийн 03 сарын 20 гээд шинэ ноолуур гарч эхлэх үед өнгөрсөн жилийнхээ түүхий эдийг дууссан байх хэмжээний бизнесийн загварыг компанийнхаа удирдлага болгож ажиллана. Ингэж ажилласнаар бид зээлээ бууруулж, ханшийн алдагдлыг бууруулах боломжтой гэж харж байгаа. Хэрэв ханш тогтвортой байсан бол бидний ашиг өндөр байх боломж байсан. Нөгөө талдаа Монгол улс 13 тэрбум долларын GDP-тэй улс, харин харамсалтай нь 28.7 тэрбум долларын гадаад өртэй. Бид GDP-ээсээ 2.3 дахин их өртэй.

Гэхдээ бид 210,000 малчин өрхийн түүхий эдийг худалдаж аваад 2,114 хүнийг байнгын ажлын байраар хангаад, илүү мундаг компани болно гэж зорьж байгаа.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Ц.Баатарсайхан захиралд баярлалаа. Хувьцаа эзэмшигчийн хувьд нэлээд чухал асуудлыг хөндлөө, баярлалаа. Үйл ажиллагаагаа ингэж өргөжүүлж байгаа үед хүүний зардал өндөр байх нь ойлгомжтой байх. Дараа жилийн бизнес төлөвлөгөөний гол гол зорилтуудыг бас сайн хараарай.

АСУУЛТ 4

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: Говь ХК-ийн нэг ажилтанд ногдох борлуулалтын орлого буюу хөдөлмөрийн бүтээмж 82 сая төгрөг байна. Энэ тоог 38% өсгөх төлөвлөгөөтэй байгаа юм байна. Хөдөлмөрийн бүтээмж хоёр дахин өссөн тохиолдолд ажилчдын цалинг 2 дахин өсгөж 2,600,000 буюу 1,000 доллар болгох уу?

Хариулт:

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Үйлдвэрлэлийн бүтээмж хоёр дахин өслөө гээд ажилчдынхаа цалинг хоёр дахин өсгөдөг компани хаана ч байхгүй ээ. Дэлхийд үйлдвэрлэлийнхээ бүтээмжээр хамгийн мундаг Тоёота компани хүртэл тийм байдаггүй.

Үйлдвэрлэлийн бүтээмж хоёр дахин өсөхөд ажилчдын цалинг 20-30% өсгөж чадвал дэлхийд маш өндөр үзүүлэлт гэж үздэг.

АСУУЛТ 5

Хувьцаа эзэмшигч н.Дашзэвэг: Гурван жилийн өмнө Д.Гэрэлмаа дарга бүтээмж өсөхийн хэрээр бид ажилчдын цалингаа нэмнэ гэж хэлж байсан. Энэ жилийн хувьд борлуулалтын орлогоороо бүтээмж 35%-иар өсвөл ажилчдын цалинг 35%-иар өсгөх боломжтой гэж харж байна.

Говь ХК маш сайн ажиллаж байгаа дээр маргах зүйл байхгүй. Гагцхүү сайныг улам сайн болгох гээд байна. Монгол залуучууд 1,000 долларын төлөө Солонгос яваад байна. Энэ цалинг Монголдоо бий болгомоор байна. Уул уурхай, барилгын салбаруудад бол ерөнхийдөө болчихоод байна. Хөнгөн үйлдвэрийн хамгийн том үйлдвэр болох Говь ХК энэ асуудлыг шийдээч ээ гэж хүсмээр байна. Өнгөрсөн онд ажилчдын дундаж цалин 1 сая төгрөг давсан байна. Үүнд баяр хүргэмээр байна. Одоо бид 2 сая төгрөг рүү яаж явах вэ.

Ер нь гадаад зах зээл рүү гарах стратеги Говь ХК-д дутагдаж байна гэж би харж байгаа. Дэлхийн ноолуурын зах зээлийн 2019 оны судалгаа байгаа. 3,500 долларын үнэтэй. Үүнийг интернэтээс татаад худалдаад авах хэрэгтэй.

Гадаад зах зээлээ тэлэх стратегээ сайжруулбал борлуулалт нэмэгдэнэ, борлуулалт нэмэгдвэл бүтээмж нэмэгдэнэ, бүтээмж нэмэгдвэл ажилчдын цалин өснө. Бүтээмжийн хэрээр цалин нэмнэ гэдэг дээр Ц.Баатарсайхан захирал санал зөрж байна. Тэгвэл тооцоо хийгээд үзье. 173 тэрбумын борлуулалтын орлоготой ажилласан, 103 тэрбум нь борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үүнээс 33 тэрбум нь цалин байгаа. Өөрөөр хэлбэл цалин маань өртгийнхөө 30% байна. Бусад улсад бол маш өндөр, жишээ нь АНУ-д 50-60% байгаа.

Ажилчдын эрх ашгийг хамгаалах талаас цалинг яаж нэмж 1,000 доллар болгох талаар Үйлдвэрчний эвлэлийн даргатай нь хамт сууж байгаад 5 жилийн төлөвлөгөө гаргаад ирье. Та бүхэн ТУЗ-өөрөө хэлэлцээд нийтэд зарлаад, Монголын хамгийн өндөр цалинтай үйлдвэр гээд Говь руу ажилд орох гээд хүсдэг компани болох ёстой гэсэн байр суурьтай байна. Миний саналыг хүлээж авах уу?

Хариулт:

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Саналыг хүлээж авах боломжгүй. Компани гэдэг бол хувьцаа эзэмшигч нэгдүгээрт байдаг, ажилчид бол түүнтэй адил хэмжээнд зэрэгцэхүйц байна гэж бодож байна. Аливаа бизнесийг хийхэд орчин бүрдэх ёстой байдаг. Жишээ нь аливаа улсын нийт эдийн засгийн GDP-ийн 10% нь аялал жуулчлалаас бүрдсэн байдаг. Тэр утгаар нь аваад үзвэл Монгол улсын эдийн засаг 13 тэрбум долларын эдийн засаг байна гэж үзвэл аялал жуулчлалаас 1.3 тэрбум долларын ашиг олдог байсан бол бидэнд борлуулалтаа өсгөх, бүтээмжээ өсгөх боломж илүү их байна гэж харж байгаа. Харамсалтай нь өнгөрсөн онд Монгол улсад ирсэн жуулчдын тоо ердөө 529,000 байна.

Гадаад зах зээл гэдэг бол Дашзэвэг багшийн яриад байгаа шиг нэг хоёр өдрийн дотор болчихдог тийм зүйл биш ээ. Дэлхий дээр ноолууран бүтээгдэхүүний 60%-ийг үйлдвэрлэж байгаа Хятад улс хүртэл дэлхийн түвшний ноолуурын брэндтэй болоогүй байгаа. Дэлхийд ноолуурын Logo Piana, Brunello Cucinelli, Zegna гэсэн Италийн гурван брэнд л байдаг. Японы автомашин хүртэл дэлхий дээр Италийн брэнд шиг болоогүй байгаа.

Мөрөөдөл ярих бол амархан, гэтэл бодит байдал дээр ажил хийнэ гэдэг мөрөөдөл ярьж байгаа шиг амархан биш шүү дээ. Би өнөөдөр ажилчдаасаа цалин харамлаагүй ээ. Гэтэл 2,100 гаруй хүнтэй компанийг удирдаж байгаа захирлын хувьд үүн дээр хариуцлагатай байхгүй бол "Та ингэж тооцоололгүй цалин нэмж компани дампууруулснаас илүү урт хугацаанд компаниа хөгжүүлээд явахгүй яасан юм бэ" гэж ажилчид надаас шаардана. Асуудал гаргаж шүүмжилж болно. Гэхдээ аливаа шүүмжлэл тооцоо судалгаатай байх хэрэгтэй гэдгийг та бүхэн ойлгоорой.

Өнөөдөр Говь ХК-ийн хамгийн үнэ цэнэтэй баялаг бол ажилтан гэдэгтэй хэн ч маргахгүй. Ер нь шинэ ажилтан авлаа гэхэд ердийн ур чадвартай хүн хэвийн ажилладаг болоход хоёр жил шаардагддаг. Үнэхээр дээд зэргийн инженер болоход 10 жил шаардагддаг. Өнгөрсөн жил Говь ХК-д 41 жилийн турш ажилласан ажилтан маань Монгол улсын аж үйлдвэрийн Гавьяат ажилтан болсон. Энэ бол залуу үеэ сургаж хөгжүүлэхэд маш ач холбогдолтой зүйл болсон гэж харж байгаа.

АСУУЛТ 6

Хувьцаа эзэмшигч Д.Хүрэлбаатар: Юуны өмнө энэ жил хувьцаа эзэмшигчдэд 5.3 тэрбум төгрөг буюу түүхэнд байгаагүй өндөр ногдол ашиг тарааж байгаа явдалд баярлаж байна. Бид энд 3 зүйлийг харах хэрэгтэй. Нэгдүгээрт компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг, хоёрдугаарт жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг, гуравдугаарт ажилчид гэсэн гурван зүйл дээр хувьцаат компани тогтож байгаа.

Говь ХК-ийн өрсөлдөгч бол дотоод өрсөлдөгчид биш гадаад өрсөлдөгчид юм. Гадаад зах зээл дээр өрсөлдөх явц бол маш удаан хугацааны явц юм. Компанийн засаглалын хувьд Говь ХК маань нэлээн мэргэжлийн төвшинд очсон нь харагдаж байгаа.

Цаашид тавих зарчмын нэг санал байна. Хямд эх үүсвэртэй зээл авахын тулд зээлийн орчин ямар байгаа билээ. Үйлдвэрлэл эрхэлж байгаа компанийн хувьд маш том зовлон байгаа. Энэ бол уул уурхайн компани биш ээ. Энэ бол маш олон жилийн хөдөлмөрийн үр дүн, ТУЗ маань компанийн засаглалыг зөв хэрэгжүүлж явж байгаагийн үр дүн гэж харж байна.

Сая анализ хийсэн байсан залуучуудын зөв, гэхдээ борлуулалт нэмэгдсэн ч түүхий эдийн үнэ өсөөд байна. Үүнийг дагаад гарах гарц маань гадаадын зах зээл дээр өрсөлдөх чадамжийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Энэ жилийн тавьсан зорилтуудын нэг болох бүтээгдэхүүнийхээ нөөцийг бууруулах нь зөв юм.

Валютын ханш дээр анализ хийгээд ханшийн өөрчлөлтөд маш мэдрэмжтэй хандаж ханшийн алдагдлыг энэ жил хаах тал дээр ажиллаасай гэж хүсч байна. Нөгөө талдаа ирэх жилээс өөрийн хөрөнгийн өгөөжийн талаарх мэдээллийг хувьцаа эзэмшигч нартаа ойлгомжтой байдлаар маш тодорхой үзүүлдэг болоорой. Дэлхийн зах зээл дээр Говь ХК өнгөрсөн жил ямар байсан энэ жил ямар болсон талаар диаграмаар харуулж байвал сайн байна. Мөн зөв сурталчилгаа явуулах хэрэгтэй. Хятадууд түүхий эдийг хамаад татвартай, татваргүй авч байгаа эсэх тал дээр төрийн бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Ирэх жил маш өндөр төлөвлөгөө тавьсан байна. Төлөвлөгөөндөө хүрээрэй гэж хүсье. Та бүхэндээ амжилт хүсье.

Хариулт:

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Баярлалаа. Гол гол санаануудыг тэмдэглээд авъя.

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Хонгконгд Li Fung гээд Дэлхийн хамгийн том хувцасны захиалагч, нийлүүлэгч компани байдаг. Энэ компанийн Ерөнхийлөгч нь 2016 онд Говь ХК-тай хамтарч ажиллая гэж яриад 2016 онд ирээд, 2017 онд ирээд, 2018 онд дэлхийн зах зээл дээр хамтарч ажиллахаар хэлэлцээр хийсэн. Энэ компанийн хүсч байгаа зүйл бол 1 гр-ыг нь 14-15 центээр авахыг л хүсдэг. Зуны оргил ачааллын үе дээрээ тийм хямд бүтээгдэхүүн үйлдвэрлээд ирвэл Говь ХК цаашид явахад хэцүү.

2018 он хүртэл баримталж ирсэн бодлогоо бид өөрчилсөн гэдгийг та бүхэнд дахин хэлье. Хойшид бид жилд 900-1,000 тн ноолуур худалдаж аваад үүнийг бүтэн жилийн туршид үйлдвэрлээд дараа жилийн 3 сарын 20-нд шинэ ноолуур гарахад ямар ч нөөцгүй компани болох зорилго тавьсан. Ингэж чадвал бид ханшийн алдагдалд хамгийн бага хэмжээнд өртөнө гэж үзэж байгаа.

Хятад улстай өрсөлдөнө гэдэг маш хэцүү. Хятадын ноолуурын компани саяхныг хүртэл түүхий эдээ бэлтгэхэд улсаасаа хүүгүй зээл авдаг байсан. Дэлхийн хамгийн том банк нь Хятадын банк л байдаг. Мөн ноолуурын тоног төхөөрөмж үйлдвэрлэж байгаа компаниуд бүгд Хятадад салбартай байдаг. Жишээ нь нэг тоног төхөөрөмж нь эвдэрлээ гэхэд Итали, Японы үйлдвэрлэгчид дуудлагаар нь өдөрт нь очоод засаад өгөх боломжтой байдаг. Харин Монгол улс бол тухайн тоног төхөөрөмж үйлдвэрлэгчийн хувьд тийм том худалдан авагч нь биш учир тухайн төхөөрөмжийг хэвийн тасалдалгүй ажиллуулахын тулд байнгын сэлбэгийн нөөцтэй байх хэрэгтэй болдог гэх мэт... Тоног төхөөрөмжийн хувьд бид 1981 онд ашиглалтад оруулсан ээрэхийн тоног төхөөрөмжөө өнөөдрийг хүртэл засаж сэлбээд ажиллуулж байгаа. Харин 2018 онд зоригтой шийдвэр гаргаад хамгийн орчин үеийн 3 мөлхөө зэрэх машин шинээр худалдаж авсан.

Дэлхийн ноолуурын 50% үйлдвэрлэж байгаа 210,000 малчин өрх байхад бид тайлбар хийгээд суугаад байх биш илүү их үйлдвэрлэлээ нэмж, илүү ихийг бүтээхийн төлөө ажиллах зорилго тавьж байгаа. Өрсөлдөөн бол ширүүн байгаа. Бид цаашид хувьцаа эзэмшигчдээ нэгт тавиад, ажилтнуудынхаа эрх ашгийг бас дээдлээд урагшлах болно.

АСУУЛТ 7

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: 1-рт, өнгөрсөн онд зээлийн хэмжээ 2 дахин өссөн байна. Арилжааны банкнаас авсан зээл маань төгрөгийн зээл үү, долларын зээл үү, эсвэл хөнгөлөлттэй зээл үү? Хэдэн хувийн хүүтэй зээл вэ?

2-рт, АНУ руу татваргүй ноолууран эдлэл гаргах хууль батлагдвал танай компани экспорт хийх боломж нээгдэх үү?

Хариулт:

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Хөгжлийн банкнаас авсан зээл маань хөнгөлөлттэй, 12%-ийн хүүтэй төгрөгийн зээл байгаа. Мөн Хөгжлийн банкнаас авсан долларын зээл 8%-ийн хүүтэй байгаа. Долларын 8% хүүтэй зээл гэдэг бол мэдээж ханшийн эрсдэл байгаа боловч маш бага хүүтэй зээл. Учир нь манай Монгол улс гадаадад бонд гаргахад 6.5-7.5% хүүтэй байгаа. Энэ жилийн хувьд Олон улсын валютын сангийн хязгаарлалтад ороод Хөгжлийн банк зээл олгохгүй байгаа. Бид арилжааны банкнаас 15.6%-ийн хүүтэй зээл аваад 2019 оны түүхий эдээ бэлтгэхээр ажиллаж байгаа.

Дэлхийн ноолуурын зах зээлийн хамгийн том зах зээл бол яах аргагүй АНУ юм. Гуравдагч хөршийн бодлого гээд МУ-ын ерөнхийлөгч АНУ-ын ерөнхийлөгчид санал тавиад

энэ хууль хэлэлцэх шатандаа явж байгаа. Энэ зун батлагдчих байх гэж харж байна. Хэрэв энэ хууль батлагдаад татваргүй болбол Хятадаас бараа авдаг Америкийн DZ групп манайхаас бүтээгдэхүүн авахаар ярьж байгаа. Ер нь татвар авах үгүйгээс эс хамааран манайд анхны захиалгаа өгөхөөр яригдаж байгаа.

АСУУЛТ 8

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: Дотоодын хэрэглэгчийн хувьд энгийн асуулт тавья. Манай ноолууран хувцасны загвар дэлхийн загварын чиг хандлагын ямар төвшинд явдаг вэ? Мэдээж гадаад руу олон улсад экспорт хийж байгаа учир маш загварлаг бүтээгдэхүүнүүд гаргадаг байх. Ер нь загварын чиг хандлага нь борлуулалтад нөлөөлдөг үү?

Дотоодын хэрэглэгчдийн саналыг ноолууран бүтээгдэхүүн дээр авдаг уу? Дотоодын хэрэглэгчдээ сэтгэлд нийцсэн бүтээгдэхүүнээр хангах бодлого байдаг уу?

Ноолуур мэдээж өндөр үнэтэй учир өнөөдөр Монголчуудын орлого бага учир тэр бүр өмсөж хэрэглэж чадахгүй байна. Иймд ноолууран бүтээгдэхүүнээ Монголчууддаа хэрхэн хэрэглүүлэх вэ?

Хариулт:

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Говь ХК-ийн нийт борлуулалтын орлогын 50%-ийг сүлжмэл бүтээгдэхүүн эзэлдэг, хоёрдугаарт оёмол бүтээгдэхүүн буюу пальто пиджак эзэлдэг, гуравдугаарт нэхмэл ороолт шааль эзэлдэг. Дэлхийн загварын чиг хандлагыг Итали улс тодорхойлдог. Говь ХК-ийн түүхийг яривал 1981 онд байгуулагдсан. 1990 оныг хүртэл жилд 1,000 тн түүхий ноолуур, 200 тн тэмээний ноос аваад анхан шатны боловсруулалт хийгээд экспортод гаргах зорилготой байгуулагдсан үйлдвэр юм. Тэгэхээр эцсийн бүтээгдэхүүн хийдэггүй байсан гэж ойлгоход болно. Говь ХК 2007 онд хувьчлагдахад жилд 100 тн ноолуур худалдаж авдаг байсан. 2008 онд Говь ХК-ийн борлуулалт 17 тэрбум байсан бол 2018 онд 173.4 тэрбум болж 10 жилийн дотор манай борлуулалт 10 дахин өссөн.

Загвар дизайнтай холбогдуулж ярихад өмнө нь Монголчууддаа зориулсан загвар гаргадаггүй байсан. 2009 оноос Италийн загвар зохион бүтээгчтэй хамтарч ажиллаад бүрэн коллекц гаргадаг болсон. Одоо улам сайжруулаад явж байгаа.

Монгол хүний бие галбарт тохирсон загвар гэдэг дээр хэлэхэд, манай ТУЗ-ийн хараат бус гишүүн ШУТИС-ийн профессор М.Баяр багш байгаа. Монгол хүний биеийн хэмжилтийг хийдэг Монголд урдаа барьдаг эрдэмтэн байгаа. Бид Монгол хүний бие галбарт тохирсон бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг хийгээд явж байгаа.

Өмнө нь ээрэхийн технологи маань хоцрогдсон байх үед сүлжмэл бүтээгдэхүүн дээр бөөсрөлт их үүсдэг байсныг 2018 онд 100% шийдвэрлэсэн гэж хэлж болно. Хуучин босоо технологиор ээрмэл утсыг 10 см зайд сунгаж ээрдэг байсан бол шинэ технологиор 3 метр сунгаж ээрдэг болсон. Иймд утасны технологи бол цоо шинэ шатанд гарсан гэж ойлгож болно.

АСУУЛТ 9

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: Би анх удаа хувьцаа эзэмшигчдийн хуралд сууж байна. Маш их баяртай байна. Монгол улс дэлхийн түүхий ноолуурын 50% хангаж байгаа ч хараахан бүгдийг нь эцсийн бүтээгдэхүүн болгон гаргаж чадахгүй байна. Түүхий эд нийлүүлж байгаа малчид маань хувьцаа эзэмшдэг үү? Малчдыг Говь ХК-ийн хувьцаанаас эзэмшүүлэх тал дээр ямар бодлого баримталдаг вэ?

Мөн миний сонссоноор түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгон Европ руу гаргах Францын төслүүд явагдаж байгаа. Хятадуудтай Монголын зах зээл дээр үнээр өрсөлдөх боломжтой юу? Хууль эрх зүйн хувьд төрийн зүгээс зах зээлээ хамгаалсан лобби хийгээд, түүхий эдээ Монголын зах зээл дээрээ боловсруулаад, эцсийн бүтээгдэхүүн болгон илүү их орлого олоход компани ямар стратеги баримталж байгаа вэ?

Хариулт:

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Малчдыг компанийн хувьцаа эзэмшигч болгох тал дээр онцгойлон хийсэн ажил одоогоор байхгүй. Харин та бүхэн бас сонссон байж магадгүй, Хятадууд ноолуурын гарцыг нэмэгдүүлэхэд сонин арга хэрэглэдэг. Ер нь ноолуур шөнө харанхуй байхад ургалт нь явагддаг тул гарцаа нэмэгдүүлэхийн тулд зориуд сартай шөнө ямаануудаа харанхуй саравчинд оруулах замаар ноолуурын гарцыг нэмэгдүүлэх арга хэрэглэдэг. Энэ нь эргээд малд таатай бус арга хэрэглэж байна гэж Европчууд шүүмжилдэг.

Хятад улстай харьцуулахад Монгол ямаа тааваараа бэлчээд, тааваараа ноолуураа самнуулдаг гэдгийг харуулах зорилгоор бид нэг төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа. Малчны хотонд дэлхийн хаанаас ч харж болох камер байршуулаад монгол ямаа онгон байгаль дээрээ идээшээд ноолуур нь ургаж байгаа, хэрхэн бэлчиж байгааг харуулах төсөл боловсруулж байгаа.

Мөн бид малчдыг хотод ирэх үед нь үйлдвэрээ танилцуулах тал дээр нээлттэй хамтарч ажилладаг. 210,000 малчин өрх гэдэг бол ойролцоогоор 600-700 мянган хүний эрх ашгийн талаар бид ярьж байна. Малчдынхаа гаргаж буй түүхий эдийг Монголдоо зах зээлийн ханшаар нь Хятадын, цаашлаад дэлхийн компаниудтай өрсөлдөж худалдан авах нь малчдынхаа эрх ашгийг хамгаалах нэг том зорилго гэж бодож байна. Түүнээс биш төр засгаараа ноолуур экспортод гаргахыг нь хориглуулаад компанийнхаа 2,000 ажилтны эрх ашгийг 210,000 малчин өрхийн эрх ашгаас дээгүүр тавихыг би огт боддоггүй. Ийм зүйл ярьдаг зарим нэг ноолуурын үйлдвэрийн хүмүүс байдаг.

Монголд ирж байгаа жуулчдын тоог нэмэгдүүлэхийн тулд 4 сарын 22-нд МУ-ын Ерөнхий сайдын ивээл дор Монголын аялал жуулчлалыг хөгжүүлэх нь гэдэг форум болох гэж байна. Үүн дээр би өөрөө илтгэл тавина. Монголын агаарын тээврийг чөлөөтэй болгох хэрэгтэй байна. Монголоос гадагшаа гарах нислэгийн үнэ өндөр байгаа тул Монголд ирж байгаа жуулчдын тоо цөөн байна. Хэрэв жуулчдын тоо нэмэгдвэл бидэнд борлуулалт хийх маш том боломж байгаа.

Жишээ нь Өвөр монгол 1,180,000 м.кв талбайтай, 25 сая хүн амьдардаг. Өвөр монгол өнгөрсөн жил 128 сая жуулчин авсны 20 сая нь гаднын жуулчин. Агаарын тээврийг чөлөөтэй болгох ёсгүй гэдэг хэтэрхий эх орончдоосоо болоод Монгол улс ердөө 529 мянган жуулчин хүлээж авч байна. Хамгийн сүүлийн статистик мэдээгээр Монголд 89 мянган хүн ажилгүй байгаа. Хэрэв энэ жуулчдын тоо 1 саяд хүрвэл энэ ажилгүйдэл алга болно.

Монголын эдийн засаг хүнд байгаа ч гэсэн Говь ХК-ийн ажилтнууд "Өдөр бүр байдаг чадлаараа өөрийн бүх чадлыг дайчлан ажиллана" гэсэн уриатай ажилладаг. Аливаа ажлыг хийхэд асуудал бэрхшээл тулгарна. Жишээ нь галын аюул нүүрлэхэд манай бүх ажилчид хэн ч зарлал тараагаагүй байхад ажилтан бүр өөрсдөө ирээд тоног төхөөрөмж машинуудаа гялгар уутаар хучаад ердөө 5 машин л хөнгөн эвдэрсэн. Ажилтнууд маань үйлдвэрээ гэсэн ямар их сэтгэлтэй вэ гэдгийг хараад би Гүйцэтгэх захирлын хувьд ажилтнуудаараа бахархсан.

6. САНАЛ ШҮҮМЖЛЭЛ

/Хүн тус бүр 3 минут/

САНАЛ, ШҮҮМЖЛЭЛ 1

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: Та бүхэн маш амжилттай ажиллаж хувьцаа эзэмшигч биднийг баярлуулж байгаад талархлаа илэрхийлье. Бид Говь ХК-ийн хувьцаа эзэмшигч гэдгээрээ, ялангуяа Говь-ийнхоо бүтээгдэхүүнээр хаа ч явсан бахархаж байдаг. Өөрсдөө бас хэрэглэж эдэлмээр байна. Үнэ нь гэхдээ их өндөр байдаг. Өнгөрсөн зун гадаадын зочид нарыгаа Монголд ирэх үед дагуулж ирээд худалдан авалт хийлгэхэд надад 9% урамшуулал өгөхөд нь би хязгааргүй их баярласан. Надад нэг санал байна. Хуралдаа ирсэн хувьцаа эзэмшигч хүмүүстээ 5-10% хөнгөлөлтийн картыг өгч болох уу?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Саналыг сонслоо, бид судалж үзье. Ер нь нийт хувьцаа эзэмшигч нартаа хандаж хэлэхэд жилд ганц энэ хурал дээр л санал шүүмжээ хэлдэг гэж битгий бодоорой. ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай байнга нээлттэй харилцаж болно шүү. Бид шүүмжлэлийг дуртай хүлээж авна.

САНАЛ, ШҮҮМЖЛЭЛ 2

Дархан-Уул аймгаас ирсэн хувьцаа эзэмшигч н.Цэдэндамба: Дэлхийн зах зээл, Монгол улсын зах зээл уналттай хүнд байгаа цаг үед Говь ХК маань гэсэн 200 мянган малчин өрх, 2,000 гаруй ажилчид, 16,000 гаруй хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг ханган сайн ажиллаж байна гэж би бодож байна. Энэ хамт олны ажлын үр дүнд хувьцааны бага ч гэсэн ногдол ашиг тараагдаж байгаа явдалд компанийн нийт удирдлагуудад баяр хүргэе. Цаашид хувьцаа эзэмшигчдийн тоог нэмэх үү? Гадаад зах зээлийн хувьд Хятадын компаниудтай түншлэх бодлого байгаа юу?

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Манай компани хувьцаагаа саяхан хуваасан. Дахиж хувьцаа эзэмшигчдийн тоон дээр энэ хэмжээний том хөдөлгөөн орохгүй байх гэж бодож байна. Хөрөнгийн зах зээл яаж ажиллах, манай хувьцаа хэр эрэлттэй байх вэ гэдгээс хамаараад зах зээлийнхээ эрэлт нийлүүлэлтийн хуулиараа л хөдөлгөөнүүд орох байх. Бид бодлогоор дахиж хувьцаа хуваах арга хэмжээг авахгүй.

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Хятад, Италийн компаниуд бол бидний өрсөлдөгчид. Италийн Loro Piana-ийн хүмүүс өнгөрсөн 7-р сард манай үйлдвэр дээр ирсэн. Тэд манай үйлдвэрийг үзье гэсэн. Харин бидний хувьд дараа Италид очих үед тэдний үйлдвэрийг бас үзнэ гэсэн нөхцөлтэйгөөр үйлдвэрээ үзүүлсэн. Loro Piana бол хамгийн том ноолуурын брэнд. Нэг цамц нь 800-1,000 долларын үнэтэй байдаг. Үнэтэй пальто нь 5,000 долларын үнэтэй байдаг. Тэд манай үйлдвэртэй танилцаад Монголчууд ингэж юм үйлдвэрлэж чаддаг болсон гэж үү гээд бараг уурлаад гарсан. Түүнийг нь сонсоод бид улам мэрийх хэрэгтэй юм байна гэж бодсон.

Монгол улсыг хөгжөөсэй гэж Хятад, Япон, Итали гээд бусад орнууд бодохгүй. Тэгэхээр бид шүүмжлэх зүйл дээрээ шүүмжлээд, хамтрах зүйл дээрээ хамтраад явах ёстой л гэж бодож байна.

САНАЛ, ШҮҮМЖЛЭЛ 3

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: Швейцарь цаг, Герман машин гэдэгтэй адил Монгол ноолуурыг дэлхийд таниулахаар ажиллаж байгаа та бүхэнд талархлаа илэрхийлье.

Эхний санал бол, ТУЗ-ийн гишүүн нь Гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байгаа нь компанийн засаглалын шилдэг туршлага мөн үү гэдгийг та бүхэн судалж үзээрэй.

Дараагийн асуулт бол, хүний нөөц бүрдүүлэлт дээр сургасан хүмүүсээ Солонгос улс болон уул уурхайн компани руу алдаж байна гэсэн. Энэ тал дээр ямар бодлого, арга баримталж байгаа юм бол гэдгийг асуумаар байна. Жилийн тайлан дээрээс харахад Захиргаа, хүний нөөцийн газрын захирал нь эзэмшсэн мэргэжил нь мэргэжлийн бус хүн шиг харагдаж байна. Энэ том албан тушаалд мэргэжлийн хүнийг нь томилох нь чухал гэж бодож байна.

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Захиргаа, хүний нөөцийн газрын захирлыг томилсон албан тушаалтныхаа хувьд би үүн дээр тайлбар өгье. Миний хувьд баримталдаг зарчим маань "Мөнгө байгаа газар санхүүгийн хүн байх ёстой, хүн байгаа газар хүний нөөцийн хүн байх ёстой". Өмнө нь хүний нөөцийн мэргэжлийн хүмүүсийг ч зөндөө ажиллуулж үзсэн. Ч.Солонго захирлын хувьд ажилд авснаас хойш дэлхийн брэнд KFC, Pizza hut-ын хүний нөөцийн сургалтад хангалттай хамруулсан. Мөн Таван Богд Группийн хүний нөөцийн газартай менежментийн төвшинд хамтарч ажилладаг. Ер нь Говь ХК-ийн хувьд Монголд байхгүй онцлогтой хүний нөөцийн бодлого хэрэгжээд явж байгаа. Үүнийг хамт олны тогтвортой байдал нотолж харуулна гэж бодож байна.

Мөн Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-д байгаа асуудал дээр тайлбар хэлэхэд Говь ХК-ийн захирлыг хамгийн сайн хийж чадна гэсэн хүн гарч ирвэл ТУЗ маань саналыг нь сонсоод томилоход бэлэн гэдгийг хэлмээр байна. Би нөгөө талдаа өөрийн хийж байгаа ажилдаа тэр хэмжээгээр итгэл үнэмшилтэй байгаа.

Дөнгөж сая хуралд орж ирэхээсээ өмнө Hyundai home shopping гээд Солонгостоо №2-т ордог компанитай 2019-2021 онуудад хамтарч ажиллах гэрээнд гарын үсэг зураад орж ирж байна.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Засаглалын хувьд Гүйцэтгэх удирдлага өөрөө ТУЗ-д байх нь сайн засаглалын зарчимтай харшилсан зүйл огт байхгүй. Засаглалын хувьд ямар нэг маргаантай асуудал үүсэх магадлалтай зүйл дээр бид засаглалын бичиг баримт, сайн засаглалын зарчмуудаа баримтлаад явдаг.

Мөн ТУЗ-ийн зүгээс Говь ХК-ийн хүний нөөцийн бодлогыг боломжийн төвшинд ажиллаж байгаа гэсэн дүгнэлтийг өгсөн. ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороон дээр хүний нөөцийн бодлоготой холбоотой асуудлыг хэлэлцэж зохицуулдаг. Орчин цагийн хүний нөөцийн удирдлагаар хэрэгжүүлэх бүх үйл ажиллагаа багцаараа хэрэгжээд явж байгаа. Үүн дээр мэргэжлийн мэдлэгтэй, мэдлэггүй гэсэн асуудал яригдахгүй.

Миний хувьд хүний нөөцийн захирал ямар хүн байх ёстой вэ гэдэг дээр хувийн бодлоо хэлэхэд, мэдээж нарийн мэргэжлийн мэдлэг удирдаж буй албанд нь байх ёстой, гагцхүү тэр хүн бол хүнийг боддог хүн л байх ёстой гэж бодож байна. Хүнээ гэсэн, ажилтнаа гэсэн хүн л энэ албаны удирдлагыг хийнэ. Том үйлдвэрийн систем дээр, ер нь ямар ч нийгмийн системд дан ганц мэргэжлийн мэдлэгээр явдаггүй юм. Энэ бол зөвхөн миний бодол шүү. Таны саналыг хүлээн авлаа. Баярлалаа.

САНАЛ, ШҮҮМЖЛЭЛ 4

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: Танайх 2,113 ажилтантай юм байна. Эдгээр хүмүүсээс хэд нь компанийнхаа хувьцаа эзэмшигч байдаг вэ? Үүнийг судалж үзээд, хэрэв бага хувьтай байвал ажилтнууд нь өөрсдөө компанийнхаа эзэн нь байх боломжоор нь хангаад, хөрөнгийн зах зээлийг сонирхох боломжийг нь бүрдүүлээд, тэр талын мэдлэг мэдээллээр нь хангах чиглэлээр ажилтнуудаа хамруулаасай гэж хүсч байна.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Баярлалаа, саналыг хүлээж авлаа. Чухал санал байна.

САНАЛ, ШҮҮМЖЛЭЛ 5

Хувьцаа эзэмшигч н.Дашзэвэг: Валютын ханшийн эрсдэлийн талаар өнөөдөр энд хэн ч ярихгүй байна. Үүнийг hedge гэдэг. Доллартай харьцаж байгаа бол hedge гэдэг зүйлийг судлах хэрэгтэй. Тэгвэл 5 тэрбумын алдагдал багасна.

Санхүүгийн албаны даргад хэлэхэд, ашигт нөлөөлж байгаа зүйлийг энэ номон дээрээ ил тавих хэрэгтэй. Үүн дээрээ анализ хий, та бүхэн сая түүхий эдийн үнэ, валютын ханшаас болсон гэж байна. Түүнийгээ хувиар гаргаад ир.

Эцэст нь Баатарсайхан захиралд захирах, Европ руу гарах гэж байгаа бол Европоос менежер авч ирээд Гүйцэтгэх захирлаар тавьбал яасан юм бэ. Нарийн ярьвал та өөрөө холбооны инженер хүн. Гэхдээ бол гайгүй удирдаж байгаа ч Европын менежерүүдтэй харьцуулахад мэдлэг дутах байх.

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Дашзэвэг багш надад компани удирдах тухай заахаасаа өмнө өөрөө сургуулийнхаа захирлын ажлыг сайн хий. Жил бүр хурал дээр ирж жүжиг тавихаа болих хэрэгтэй. Би 16,000 гаруй хувьцаа эзэмшигчийнхээ эрх ашгийн төлөө ажилладаг.

Өөрийг тань компанийнхаа Хяналтын албаны гишүүнээр 2 жил гаруй ажиллуулж үзсэн. Тэр хооронд ажлаа хийхийн оронд өөрийн гадаад руу явах хувийн зардлаа даалгах хүсэлт л тавьдаг байсан. Манай хамт олон таны зардлыг даадаг байгууллага биш шүү дээ. Ер нь байж байгаад л сургуулийнхаа ханан дээр реклам тавиач ээ гэж над руу утастдаг. Та жил бүр Говь ХК-ийн хурлыг ингэж битгий үймүүлж бай. Юманд хэмжээ хязгаар байх ёстой. Ёс суртахуунтай байх хэрэгтэй.

Би өнөөдөр хувьцаа эзэмшигч нарынхаа бүх асуултад хугацаанд нь хариулт өгөөд хүндэтгэлтэй хандаж байна.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Баярлалаа, таны саналыг хүлээж авлаа. Валютын ханшийн эрсдэл байсан. Үүн дээр цаашид шинжилгээтэй хандаж, удирдана. Дараа жилийн санхүүгийн тайланг та бүхэнд ойлгомжтой байдлаар танилцуулна. Компани маань үнэхээр өргөжөөгүй, үйл ажиллагаа нь ингэж тэлээгүй бол энэ хэмжээний зардал гарахгүй байсан. Том хэмжээний хөрөнгө оруулалтууд хийж байгаатай холбоотой эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн зээл авсан. Зээл маань төгрөг, долларын зээлүүд байдаг. Мөн гадаадад үйл ажиллагаа явуулахын тулд сурталчилгааны үйл ажиллагаа явуулна, судалгаа хийнэ. Тэгэхээр энэ хэмжээний зардлууд гарахаас өөр аргагүй.

Дараа жилийн бизнес төлөвлөгөөний зорилтуудыг та бүхэн харсан байх. Том хэмжээний хөрөнгө оруулалтууд байхгүй, хүчин чадлаа тултал нь ашиглана гэсэн зорилт тавьсан байгаа.

Таны саналуудыг хүлээн авлаа. ТУЗ-ийн зүгээс санхүүгийн үзүүлэлтүүдийг хүн болгонд ойлгомжтой, нарийн шинжилгээтэй гаргаж тавья.

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Нэмэлтээр Говь ХК-ийн талаар мэдээлэл өгөхөд Хөрөнгийн бирж дээр компанийн үнэлгээгээгээрээ 4-т байгаа гэж түрүүн ярьсан. 1-рт АПУ ХК, 2-рт жижиг Таван толгой ХК, 3-рт МИК ХК, 4-рт Говь ХК байдаг.

Үйл ажиллагаагаа сайжруулахын төлөө манай хамт олон өдөр бүр мэрийдэг. Бидэнд бодитой шүүмжлэл хэрэгтэй. Бодитой шүүмжлэлүүдээ та бүхэн жилд ганц болдог Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр хэлэхээс гадна өдөр тутам ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан бичгээр болон имэйлээр хэзээд нээлттэй мэдэгдэж болно шүү. Бид болохгүй байгаа зүйлсээ ойлгохын тулд байнга дүгнэлт хийж ажилладаг. Тийм ч учраас бид 10 жилийн дотор борлуулалтаа 10 дахин өсгөж чадсан. Та бүхэнд баярлалаа.

7. САНАЛ ХУРААЛТ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ санал өгөх санамжийг танилцуулан санал хураалтыг эхлүүлсэн бөгөөд санал хураалт 10 минут үргэлжлэв.

8. САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ НЭГТГЭХ

Тооллогын комисс саналын хайрцгийг задлан, санал хураалтын дүнг нэгтгэв.

9. САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ

Тооллогын комиссын дарга М.Болортуяа танилцуулав.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 67.3, Говь ХК-ийн дүрмийн 6.1.10-6.1.16 заалтыг удирдлага болгон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалтын дүнг нэгтгэн тоолсныг үндэслэн ТОГТООХ НЬ:

- Нэг.** Санал хураах хайрцгаар **51.99** хувийн саналын эрхтэй **405,581,513** ширхэг хувьцааны **242** ширхэг саналын хуудас хураасныг тооцсугай.
- Хоёр.** Шуудангаар дамжуулж дамжуулж **34.00** хувийн саналын эрхтэй **265,238,300** ширхэг хувьцааны **1** ширхэг саналын хуудас ирүүлснийг дурьдсугай.
- Гурав.** Брокерийн пүүсүүдээр дамжуулж **2.64** хувийн саналын эрхтэй **20,615,000** ширхэг хувьцааны **2** ширхэг саналын хуудас ирүүлснийг дурьдсугай.
- Дөрөв.** Говь ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.96** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

Тооллогын комиссын дарга
Нарийн бичгийн дарга
Гишүүд

М.Болортуяа
Н.Сайнзул
Ц.Цэцэгбадам
Б.Уянга

10. ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫГ ТАНИЛЦУУЛАХ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.

Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.9.10 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, ТУЗ-өөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2019 оны 04 сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Говь ХК-ийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА Д.ГЭРЭЛМАА

Хавсралт 1:

ГОВЬ ХК-ИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Говь ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2018 оны зорилтуудын талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгож, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 2018 оны бизнес төлөвлөгөө нь мөлхөө зэрэх машинаар сүлжмэлийн утсыг үйлдвэрлэдэг болж утасны чанарыг сайжруулах, нэхмэлийн гүйцэтгэн боловсруулах технологийг Япон улсаас суралцаж эзэмших, дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц пиджак үйлдвэрлэх технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, гадаад дотоод захиалгыг үйлдвэрлэлтэй нягт хослуулан үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх,

үйлдвэрлэлийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, гадаад дахь нэрийн болон гэрээт дэлгүүрүүдийн үйл ажиллагааг сайжруулах замаар борлуулалтыг нэмэгдүүлэх, санхүүгийн үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллахад чиглэсэн билээ.

Говь ХК 2018 онд 173.4 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж бизнес төлөвлөгөөний биелэлт 115%, цэвэр ашиг 17.8 тэрбум төгрөгт хүрч ашгийн төлөвлөгөө 94%-ийн гүйцэтгэлтэй гарлаа. Гадаад борлуулалт 2018 онд 61.6 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 114 хувь, дотоод борлуулалт 111.9 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 116 хувьд хүрчээ.

Мөн тайлант жилд 762 тонн түүхий эд бэлтгэж, нийт 29.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 12.8 тэрбум төгрөг буюу 43%-ийг барилга байгууламжийн бүтээн байгуулалт, 15.0 тэрбум төгрөг буюу 51%-ийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 1.7 тэрбум төгрөг буюу 6%-ийг бусад хөрөнгө оруулалтад зориулсан байна.

Иймд Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2018 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хурал 12 цаг 30 минутад өндөрлөв.

Хурлын даргалагч:

ТУЗ-ийн дарга



Д.ГЭРЭЛМАА

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Архив, бичиг хэргийн мэргэжилтэн



Б.АНХЧИМЭГ